

“ЭРДЭНЭС СОЛЮШИНС” ХК

2022 оны 04 дүгээр сарын 30-ний өдөр

№ ХТ 01/2022

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн 12.00 цагаас 12.40 цагын хооронд Google Meet joining info; Video call link: <https://meet.google.com/mmi-dmwe-rnc> програмыг ашиглан хуралдав.

Хурал зохион байгуулах комисс болон Тооллогын комиссоос хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, ирц 81.17/наян нэг зууны арван долоо/ хувь буюу 128,142,604 /нэг зуун хорин найман сая нэг зуун дөчин хоёр мянга зургаан зуун дөрөв/ ширхэг саналын эрхтэй хувьцааг эзэмшигчид оролцож байгаа талаар танилцуулж, хурлын ирц компанийн дүрэм болон хуулийн дагуу бүрдсэн тул хурал хүчин төгөлдөрт болсон тухай Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Субашид тек ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Т. Золбоо, хувьцаа эзэмшигч Г. Дулмааг төлөөлж иргэн Б.Батхүү нар итгэмжлэлээр хуралд оролцов. Компанийн зүгээс цахим хурлыг бичлэг хийж хадгалав.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэрийн 2 дугаар хавсралтад заасан “Хурлын хөтөлбөр, дэг”-ийн дагуу хэлэлцэх асуудлын эхэнд хувьцаа эзэмшигчдээс хурлын даргыг сонгов.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

1. Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах тухай;
3. Компанийн хаяг дүрэмд тусгах тухай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Т.Золбоо хувьцаа эзэмшигчдийн хурлын хөтөлбөрийн дагуу хурлыг нээж хурлаар компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг танилцуулахыг ТУЗ-ын гишүүн Б.Батхүүгээс хүсэв.

Б.Батхүү: Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан хувьцаа эзэмшигчдийн хурлын материал болон МХБ-ын сайтад тавигдсан байгаа. Хувьцаа эзэмшигчид уншиж танилцсан байгаа. Гол хэсгүүдийг уншиж танилцуулья.

1-р хэлэлцэх асуудлаар:

Компани 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ПиКэй Эф Монголиа Аудит ХХК-иар хийлгэсэн болно. Компанийн актив хөрөнгө 2.9 тэрбум төгрөгт хүрсэн. Үүнд: Бараа материал 91 сая, Урьдчилж төлсөн зардал 46.5 сая төгрөг, Үндсэн хөрөнгө 297 сая, биет бус хөрөнгө 1.5 тэрбум төгрөг, Урт хугацаат хөрөнгө оруулалт буюу охин компаниудын хувьцаа 89 сая төгрөг байна. Бондын өр болон бусад өр 782 сая, хувь нийлүүлсэн энгийн хувьцаа 1.6 тэрбум, хуримтлагдсан ашиг 535 сая төгрөг байна. Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2021 оны жилийн үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж байна.

2-р хэлэлцэх асуудлаар:

2022 ОНЫ 04-Р САРЫН 30-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА / Т. ЗОЛБОО/



Компанийн 4 охин кампани болох Эрдэнэс капитал маркетс ХХК, Эрдэнэс агро энд ресортс ХХК, Эрдэнэс рийл эстэйт ХХК ковидын нөхцөл байдлын улмаас үйл ажиллагаа эрхлээгүй байна. Компанийн бүтээгдэхүүн, хөгжүүлж буй төсөл
D³ARS систем

Энэ систем нь хувьцаат компани, хөрөнгө оруулалтын сангууд болон койн гаргагч эрх бүхий этгээдүүдийн нийтэд мэдээлэх үүрэг бүхий мэдээллийг мэдүүлэх, **цахим өгөгдөл цуглуулах, баримт бичигт дүн шинжилгээ хийх, олж авах буюу** англиар **the Digital Data Disclosure, Analysis and Retrieval System** болон **the Digital Data Gathering, Analysis, and Retrieval System** гэх үгнүүдийн эхний үсгүүдийн нийлбэр, оюуны өмч бүхий **D³ARS** системийг 2019 оноос хойш хөгжүүлж дуусгаад байна. **D³ARS** систем нь мэдээлэх үүрэг бүхий этгээдүүдийн тухай бүр мэдүүлж буй мэдээллийг огноо болон цагаар бүртгэж, мэдүүлсэн мэдээллийг мэдээллийн санд цуглуулан, цугларсан мэдээллийг интернетээр дамжуулан олон нийтэд чөлөөтэй хүргэх боломжтой систем юм. Тухайлбал Монголын хөрөнгийн бирж болон бусад санхүү, бараа таваарын арилжааны биржид оролцогч олон нийтийн компаниуд, бусад үнэт цаас гаргагчид болон оролцогч байгууллагууд хууль, төрийн эрх бүхий байгууллагын журмаар шаардсан мэдээллийг /дата өгөгдөл/ мэдүүлэг гаргах замаар заавал бүрдүүлэх, мэдээллийг тогтсон маягтын дагуу системд оруулах замаар цуглуулж, баталгаажуулах, индексжүүлэх, хүлээн авах, дамжуулах, хайх ажлыг энэ систем гүйцэтгэнэ.

Арилжаа хийх “Брокерсмен” системийн танилцуулга

Хөрөнгийн зах зээлд оролцогч брокерийн компаниуд, тэдгээрийн харилцагчидад үнэт цаасны арилжааны эскроу данс нээхэд иргэд өөрийн биетээр цаг хугацаа, зардал гаргалгүйгээр данс нээх, үнэт цаасны арилжаанд оролцох, брокерийн компаниуд харилцагчдадаа чанартай хурдан 24/7 үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Арилжаа хийх “Брокерсмен” систем нь ямар нэгэн бүтээгдхүүний арилжааны бирж болон хөрөнгийн бирж дээр иргэн аж ахуйн нэгж оролцож арилжаа хийх, брокерийн болон банк санхүүгийн байгууллагуудын харилцагчийн бүртгэл үүсгэх, хөтлөх, харилцагчийн харилцах дансны бүртгэл хөтлөх, үнэт цаасны төлбөр тооцоо хийх, хувьцааны бүртгэл хийх хөтлөх цогц систем юм.

Банк бус санхүүгийн байгууллагын бүртгэлийн систем

Энэ систем нь Банк бус санхүүгийн байгууллагын суурь бүртгэлийн ерөнхий дэвтэр, харилцагчийн бүртгэл хөтлөх, тайлан мэдээ, санхүүгийн тайлан гаргах, он лайн горимд зээл олгох зэрэг бусад хэрэгцээт модулыг агуулсан систем нь дараах шийдлүүдтэй байна.

Төлөөлөн удирдах зөвлөл 2021 онд 11 удаа хуралдсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд 2021 онд хуралдаа 100 хувь ирцтэйгээр оролцсон бөгөөд өвчтэй, чөлөөтэй, тасалсан гишүүд байхгүй.

Хурлаар хэлэлцсэн асуудлууд болон их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлэлцэх асуудалд санал өгсөн байдал

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны хуралдаанаар нийт 51 асуудлаар санал хураасан байна. Үүнээс Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд сонирхолын зөрчилтэй 11 хэлцэлд санал өгөнөөс, 100 хувь зөвшөөрсөн санал өгсөн бөгөөд их хэмжээний хэлцэл хийх талаар хуралдаагүй байна.

Үлй ажиллагааны тайлангийн Хавсралт 2-оос Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны хуралдааны ирц болон хуралдаанаар хэлэлцсэн асуудлууд, гишүүдийн санал өгсөн байдалыг харна уу.

Хурлын дарга Ц. Золбоо: Компани 133 м2 талбай бүхий оффисын зориулалттай үл хөдлөх хөрөнгө худалдан авсан компанийн оршин байгаа газар, хаягийг Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40 50 мянгат, Бакула ринбучийн гудамж, 30-р байр, 10-р давхар гэж өөрчилье.

2022 ОНЫ 04-Р САРЫН 30-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА

/ Т. ЗОЛБОО/

Хөтөлбөрийн дагуу хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой санал, асуулга явуулья.

Хувьцаа эзэмшигчидээс ямар нэгэн санал, асуулга явагдсангүй тул санал хэлэлцэж байгаа асуудлаар санал хураалт явуулья. Хэлэлцэх асуудал тус бүрийг цахимаар гар өргөж санал аа өгнө үү. Тооллогын комисс үүнийг бүртгэж авна уу.

Тооллогын комиссын дарга Г. Төгөлдөр: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав. Үүнд хэлэлцэж буй 3 асуудлаар хувьцаа эзэмшигчид санал ирүүлээ. Өөр брокерийн компаниар дамжуулан ямар нэгэн саналын хуудас ирсэнгүй болно. Хуралд оролцож буй санал өгсөн саналын хуудсыг тоолоход хүчингүй болсон, түдгэлзсэн, эсрэг саналтай саналын хуудас гарсангүй. Саналын хуудас дараах байдлтай байна. Үүнд:

№	Хэлэлцсэн асуудлууд	Ээлжит хуралд оролцож буй санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн								Нийт	
		Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн		Хүчингүй болсон			
		ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь
1	Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг батлах тухай	128,142,604	100%							128,142,604	100%
2	Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг батлах тухай	128,142,604	100%							128,142,604	100%
3	Компанийн оршин байгаа газар, хаягийг солих тухай	128,142,604	100%							128,142,604	100%

Хурлын дарга Т.Золбоо: Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтгэйгээр хэлэлцэж буй асуудлуудыг дэмжсэн байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төсөлд ямар нэгэн санал байна уу.

Хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтгэйгээр саналгүй тул Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарч буй шийдвэрийг уншиж танилцуулав.

“ЭРДЭНЭС СОЛЮШИНС” ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН 2022 ОНЫ 04-Р САРЫН 30-НИЙ ӨДРИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ДАРААХ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭВ. ҮҮНД:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлав;
2. Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
3. Компанийн хаяг дүрэмд тусгаж батлав.

ХУРЛЫН ДАРГА

/ Т.ЗОЛБОО/

2022 ОНЫ 04-Р САРЫН 30-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА

/ Т.ЗОЛБОО/